

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **СНАГ-2023/30/НА-СТА-ТЕЗ**

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Долгоржав Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД С.АМАРСАЙХАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 4,975.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна. Тухайлбал:

- Харьяа байгууллагууд төсвийг зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн, олон жилийн насжилттай авлага, өр төлбөрийг барагдуулаагүй 656.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн;
- Ашиглалтын шаардлага хангахгүй болсон автомашин, барилга байгууламжийг шийдвэрлээгүй, хөрөнгийг дутуу тайлагнасан, бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, зэрэг 1, 031.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5. дах заалтуудыг зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд дараах бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг хийсэн байна. Үүнд:

- Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, шинээр анги, салбар, нэгж байгуулах, гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангах, чадавхыг бэхжүүлэх зорилгоор Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, судалгаа, туршилт, үйлдвэрийн төв 123 дугаар ангийг шинээр байгуулж, Улсын хэмжээнд гамшгийн үеийн шуурхай удирдлага зохицуулалтыг хэрэгжүүлэх, хүч хэрэгслийг хуваарилах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах зорилгоор Шуурхай

удирдлага, зарлан мэдээллийн төв 119 дүгээр ангийн үйл ажиллагааг тус тус эхлүүлсэн;

- Засгийн газрын 2022 оны 417, 469 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгаж, Шадар сайдын 2023 оны 05, 21 дүгээр тушаалаар Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын төв лабораторийг Стандарт, хэмжил зүйн газарт нэгтгэн, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийг Стандарт, хэмжил зүйн газрын дэргэд байгуулж, бүтцийг баталсан;
- Шадар сайдын 2023 оны 34 дүгээр тушаалаар Төрийн худалдан авах ажиллагааны газрыг 3 газар, 2 хэлтэс, 1 албатайгаар үйл ажиллагаа явуулахаар бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилсан Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, нуурын ёроолын аюултай хог хаягдлыг цэвэрлэх, бохирдлыг бууруулах, живсэн тээврийн хэрэгслийг илрүүлэх, татан гаргах ажиллагаанд Онцгой байдлын байгууллага, Зэвсэгт хүчин, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн эрдэмтэн, судлаачид, судалгаа шинжилгээний мэргэжлийн байгууллагуудтай хамтран Хөвсгөл нуурт 7-55 жил болсон 7 тээврийн хэрэгслийг 33-128 метр хүртэлх гүнээс татан гаргаж, нийт 50.0 орчим тонн бохирдлыг аюулгүй болгож, 1,017.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсанаар ТӨБЗГ-ын 2022 оны 114 дүгээр тогтоол, 2023 оны 109 тогтоолоор нийт 28,813.2 сая төгрөг, Нийслэлийн Засаг даргын а/855 дугаар захирамжаар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 1,960.8 сая төгрөг нийт 30774.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, мөн 1092.8 сая төгрөгийн бараа материалыг Стандарт, хэмжил зүйн газрын санхүүгийн тайланд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 3 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс биелэлт 90.5 хувийг гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ

Д.ЗАГДЖАВ

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	205,715,355.8	195,524,414.0
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,558,352.9	531,263.8
АВЛАГА	23,404,055.3	20,907,181.7
УРЬДЧИЛГАА	8,913,472.6	1,836,397.7
БАРАА МАТЕРИАЛ	76,578,111.7	83,663,764.6
НӨӨЦИЙН БАРАА	72,827,527.0	79,530,958.9
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	22,433,836.3	9,074,847.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	346,230,254.9	373,808,509.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	346,230,254.9	373,808,509.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	551,945,610.7	569,332,923.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,452,511.7	5,189,716.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,452,511.7	5,189,716.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	547,493,099.0	564,143,206.9
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	547,493,099.0	564,143,206.9
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	551,945,610.7	569,332,923.3

2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	324,889,222.7	290,470,100.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,464,784.1	72,341,270.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	235,424,438.6	218,128,829.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	237,718,348.6	234,411,407.6
УРСГАЛ ЗАРДАЛ	237,718,348.6	234,411,407.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	203,996,332.9	211,307,126.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,758,496.4	108,932,819.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,754,836.0	4,581,922.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,647,037.3	8,354,954.1
Хангамж, бараа материалын зардал	10,648,051.9	7,818,874.8
Нормативт зардал	10,338,695.7	10,138,265.0
Эд хогшил, урсгал засварын зардал	6,819,774.6	6,353,920.3
Томилолт, зочны зардал	2,153,272.1	1,460,363.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,033,037.3	18,951,071.2
Бараа үйлчилгээний бусад зардал	51,843,131.6	44,715,696.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,722,015.8	23,103,520.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	87,170,874.0	56,058,692.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	42,496.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	684,461,319.0	51,407,509.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(597,290,444.9)	4,693,679.9

3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	256,366,018.7	240,026,752.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,012,628.9	16,778,904.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	238,353,389.8	223,247,848.5
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	238,701,822.4	217,331,094.7
УРСГАЛ ЗАРДАЛ	238,701,822.4	217,331,094.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	200,120,276.8	186,019,320.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,178,521.3	108,172,884.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,771,375.9	4,665,281.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,717,480.0	8,047,654.1
Хангамж, бараа материалын зардал	6,768,142.4	6,254,606.6
Нормативт зардал	10,116,639.1	6,573,322.0
Эд хогшил, урсгал засварын зардал	9,171,643.4	5,677,116.6
Томилолт, зочны зардал	2,090,534.3	1,433,796.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,084,344.7	19,612,575.3
Бараа үйлчилгээний бусад зардал	47,221,595.7	25,582,083.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,581,545.6	31,311,774.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	17,664,196.3	22,695,658.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	0.0	23,722,747.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	29,133,278.7	23,722,747.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,133,278.7	23,722,747.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(29,133,278.7)	(23,722,747.2)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(11,469,082.4)	(1,027,089.1)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,027,435.1	1,558,352.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,558,352.7	531,263.8

4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,143,950,367.8	0.0	1,143,950,367.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	237,874.5	0.0	237,874.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,144,188,242.3	0.0	1,144,188,242.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	(304,534.1)	0.0	(304,534.1)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	899,835.7	0.0	899,835.7
Тайлант үеийн үр дүн	(597,290,444.9)	0.0	(597,290,444.9)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	547,493,099.0	0.0	547,493,099.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	12,553,772.9	0.0	12,553,772.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	560,046,872.0	0.0	560,046,872.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	(1,767,059.4)	0.0	(1,767,059.4)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,169,714.4	0.0	1,169,714.4
Тайлант үеийн үр дүн	4,694,298.7	0.0	4,693,679.9
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	564,143,825.7	0.0	564,143,206.9

5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	203,652,998,800.00	202,762,663,400.31	890,335,399.69	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	178,729,454,900.00	177,888,153,628.31	841,301,271.69	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	160,428,254,100.00	159,729,667,858.85	698,586,241.15	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	107,632,154,800.00	107,395,149,051.41	237,005,748.59	99.8
210101	Үндсэн цалин	53,693,543,100.00	55,118,423,873.11	(1,424,880,773.11)	102.7
210102	Нэмэгдэл	49,077,265,700.00	47,255,302,945.97	1,821,962,754.03	96.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,708,304,200.00	2,895,457,797.70	(187,153,597.70)	106.9
210104	Урамшуулал	2,153,041,800.00	2,125,506,359.63	27,535,440.37	98.7
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	458,075.00	(458,075.00)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,700,106,700.00	4,572,230,254.06	127,876,445.94	97.3
210201	Тэтгэврийн даатгал	1,732,782,500.00	1,685,230,119.53	47,552,380.47	97.3
210202	Тэтгэмжийн даатгал	204,583,400.00	199,583,006.44	5,000,393.56	97.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	163,668,800.00	157,266,271.04	6,402,528.96	96.1
210204	Ажилгүйдлийн даатгал	40,916,400.00	39,017,810.09	1,898,589.91	95.4
210205	Эрүүл мэндийн даатгал	2,558,155,600.00	2,491,133,046.96	67,022,553.04	97.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,089,293,500.00	7,896,604,382.76	192,689,117.24	97.6
210301	Гэрэл, цахилгаан	1,947,499,000.00	1,773,231,849.04	174,267,150.96	91.1
210302	Түлш, халаалт	4,933,466,200.00	4,978,808,312.36	(45,342,112.36)	100.9
210303	Цэвэр, бохир ус	457,802,700.00	407,695,974.73	50,106,725.27	89.1
210304	Байрны түрээс	750,525,600.00	736,868,246.63	13,657,353.37	98.2
2104	Хангамж, бараа материалын зардал	4,959,354,000.00	4,951,439,673.29	7,914,326.71	99.8
210401	Бичиг хэрэг	211,621,700.00	215,548,923.46	(3,927,223.46)	101.9
210402	Тээвэр, шатахуун	3,789,629,300.00	3,788,579,460.28	1,049,839.72	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	235,975,400.00	229,063,462.64	6,911,937.36	97.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	36,256,500.00	34,115,715.50	2,140,784.50	94.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	685,871,100.00	684,132,111.41	1,738,988.59	99.7
2105	Нормативт зардал	6,436,365,000.00	6,425,977,884.78	10,387,115.22	99.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	590,597,000.00	583,253,893.66	7,343,106.34	98.8
210502	Хоол, хүнс	3,090,669,500.00	3,088,134,290.12	2,535,209.88	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,755,098,500.00	2,754,589,701.00	508,799.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,849,898,500.00	6,838,167,851.81	11,730,648.19	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,004,452,400.00	994,089,116.24	10,363,283.76	99.0
210602	Тавилга	8,333,800.00	8,324,900.00	8,900.00	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	51,821,200.00	51,728,604.00	92,596.00	99.8
210604	Урсгал засвар	5,785,291,100.00	5,784,025,231.57	1,265,868.43	100.0
2107	Томилолт, зочны зардал	436,404,200.00	432,817,289.00	3,586,911.00	99.2
210702	Дотоод албан томилолт	436,404,200.00	432,817,289.00	3,586,911.00	99.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,398,162,100.00	20,295,471,075.13	102,691,024.87	99.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,412,663,700.00	16,362,955,931.58	49,707,768.42	99.7

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	23,135,000.00	20,237,000.00	2,898,000.00	87.5
210803	Даатгалын үйлчилгээ	3,188,077,200.00	3,186,452,055.43	1,625,144.57	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	86,490,600.00	75,531,365.14	10,959,234.86	87.3
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	28,930,600.00	25,857,300.00	3,073,300.00	89.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	261,408,700.00	257,401,768.46	4,006,931.54	98.5
210807	Газрын төлбөр	262,015,000.00	232,755,044.52	29,259,955.48	88.8
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	577,800.00	146,100.00	431,700.00	25.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	134,863,500.00	134,134,510.00	728,990.00	99.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	926,515,300.00	921,810,396.61	4,704,903.39	99.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	496,969,800.00	493,858,673.61	3,111,126.39	99.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	429,545,500.00	427,951,723.00	1,593,777.00	99.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,301,200,800.00	18,158,485,769.46	142,715,030.54	99.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	492,517,600.00	492,427,381.46	90,218.54	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	492,517,600.00	492,427,381.46	90,218.54	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,808,683,200.00	17,666,058,388.00	142,624,812.00	99.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,792,786,500.00	8,791,316,985.00	1,469,515.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,410,900.00	4,410,900.00	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,099,212,500.00	7,961,247,232.00	137,965,268.00	98.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	912,273,300.00	909,083,271.00	3,190,029.00	99.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,923,543,900.00	24,874,509,772.00	49,034,128.00	99.8
220001	Барилга байгууламж	7,543,801,700.00	7,495,156,124.00	48,645,576.00	99.4
223001	Бусад хөрөнгө	8,500,000,000.00	8,500,000,000.00	0.00	100.0
224001	Стратегийн нөөц хөрөнгө	8,879,742,200.00	8,879,353,648.00	388,552.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	203,652,998,800.00	202,802,039,734.17	850,959,065.83	99.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	190,077,893,200.00	188,120,147,992.32	1,957,745,207.68	99.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	190,077,893,200.00	188,120,147,992.32	1,957,745,207.68	99.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,575,105,600.00	14,681,891,741.85	(1,106,786,141.85)	108.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,545,191,600.00	14,677,416,436.85	(1,132,224,836.85)	108.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,914,000.00	4,475,305.00	25,438,695.00	15.0
IV	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	34,801.89	-	-
V	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,801.89	0.00	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1633	1521	112	93.1
610001	Төсвийн байгууллага	23	23	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23	23	0	100.0
620001	Удирдах ажилтан	805	749	56	93.0
620002	Гүйцэтгэх ажилтан	35	39	(4)	111.4
620003	Үйлчлэх ажилтан	648	594	54	91.7

6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		42,573,845,735.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ		41,271,224,152.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		31,583,523,967.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		777,735,338.84
210101	Үндсэн цалин		180,337,330.36
210102	Нэмэгдэл		133,757,968.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт		3,376,248.13
210104	Урамшуулал		2,574,901.50
210105	Гэрээт ажлын хөлс		457,688,890.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		93,050,961.48
210201	Тэтгэврийн даатгал		77,041,135.87
210202	Тэтгэмжийн даатгал		1,339,645.67
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,269,678.19
210204	Ажилгүйдлийн даатгал		235,692.49
210205	Эрүүл мэндийн даатгал		13,164,809.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		151,049,725.08
210301	Гэрэл, цахилгаан		58,229,732.04
210302	Түлш, халаалт		66,630,923.49
210303	Цэвэр, бохир ус		11,189,069.55
210304	Байрны түрээс		15,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,320,640,237.50
210401	Бичиг хэрэг		87,209,645.00
210402	Тээвэр, шатахуун		1,075,875,509.02
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		7,797,908.26
210404	Ном, хэвлэл		17,801,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		21,528,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		110,427,375.22
2105	Нормативт зардал		1,062,658,066.09
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		27,303,293.00
210502	Хоол, хүнс		628,471,773.09
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		406,883,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,522,286,451.05
210601	Багаж, техник, хэрэгсэл		468,167,352.00
210602	Тавилга		68,848,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		12,170,000.00
210604	Урсгал засвар		973,100,299.05
2107	Томилолт, зочны зардал		1,000,978,781.00
210701	Гадаад албан томилолт		32,318,922.00
210702	Дотоод албан томилолт		968,659,859.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,656,893,284.41
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,620,376,313.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		2,490,500.00
210803	Даатгалын үйлчилгээ		2,792,854.43
210804	Тээврийн хэрэгслийн татвар		491,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		27,793,166.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		2,894,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		23,998,231,122.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		23,671,189,402.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		327,041,720.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		9,687,700,184.62
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,110,457,011.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		112,475,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		997,982,011.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		8,577,243,173.62
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		8,577,243,173.62
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,302,621,582.74
2200	Дотоод эх үүсвэрээр		1,302,621,582.74
221001	Их засвар		94,000,000.00
223001	Бусад хөрөнгө		304,050,000.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө		36,873,596.74
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		867,697,986.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		42,573,540,864.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		42,573,540,864.04
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,374,675,521.18
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		21,114,454,567.51
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,434,172,086.80
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		14,650,238,688.55
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		(304,871.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		304,871.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Монгол Улсын Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 24,941.2 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 9,554.9 сая төгрөгийн 143 зөрчил илэрснээс 17.4 сая төгрөгийн зөрчилд 19 төлбөрийн акт тогтоож, 2,668.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 55 албан шаардлага хүргүүлж, 2,290.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 69 зөвлөмжийг өгсөн.

Аудитаар илэрсэн 4,975.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 2,377.2.8 сая төгрөгөөс өндөр тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Харьяа байгууллагууд

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 73 төсвийн захирагч нарын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 49 байгууллагад дүгнэлт гаргаж, 24 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” 42, “Хязгаарлалттай” 7 (*Онцгой байдлын ерөнхий газрын-ТТЗ, Стандарт, хэмжил зүйн газар-ТТЗ, Онцгой байдлын ерөнхий газрын ТШЗ, Стандарт, хэмжил зүйн газар-ТШЗ, ХАБҮЛЛ, Төв, Хэнтий аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс*) дүгнэлт өгсөн.

5.2 Түүвэрт хамрагдсан төсвийн шууд захирагч

Үндэсний итгэмжлэлийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудитаар нийт 85.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 50.9 сая төгрөгийн алдааг залруулан, 35.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг өгсөн.

5.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндэсний итгэмжлэлийн төв тайлант хугацаанд 25.4 сая төгрөгийн авлага үүсгэж, гэрээний хэрэгжилтийг хангуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, 16 дугаар зүйлийн 16.5.1-д *"төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулах, шинээр үүсгэхгүй байх, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулж ажиллах, цаашид зөрчлийг давтахгүй ажиллах.

2. Орлогын төлөвлөлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх төсвийн зарчмын дагуу жил бүр байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлдэг орлогыг төсвийн төсөлд тусгаагүй, төлөвлөгөөнд батлуулж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана: 27.1.7.орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг бодитой, зөв төлөвлөх, батлагдсан төлөвлөгөөг биелүүлэх, цаашид зөрчлийг давтахгүй ажиллах.

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 27 нэр төрлийн 62 ширхэг 9.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, ашиглах хугацааг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ".

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн цаашид ашиглах дээрх хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх, данс бүртгэлдээ тусгах, цаашид зөрчлийг давтахгүй ажиллах.

5.3 Төсвийн ерөнхийлөн захирагч

5.3.1 Албан шаардлага

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нарын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 7 байгууллага "Хязгаарлалттай" дүгнэлт авч, нийт 9,554.9 сая төгрөгийн 174 зөрчил илэрснээс санхүүгийн тайлантай холбоотой 3,577.9 сая төгрөг, нийцлийн асуудалтай холбоотой 5,977.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Дотоод хяналт хангалтгүйгээс зөрчил, дутагдал буурахгүй давтан гарч байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэх, аудитаар илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийх,

давтан гаргахгүй байх талаар нэгдсэн арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, албан шаардлага хүргүүлээ.

5.3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Стандарт, хэмжил зүйн газар нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр нэмэгдүүлэн тогтоож 153.3 сая төгрөг, төрийн үйлчилгээний ажилтнуудын ур чадварын нэмэгдлийг олгох шалгуур үзүүлэлтийг тогтоож батлаагүй, хавтгайруулан 25 хувиар тооцож нийт 12.1 сая төгрөгийг олгосон байна. Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоол 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 1-д “Төрийн үйлчилгээний албан хаагчийн ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг нь дэмжиж, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор ур чадварын нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.”, 4-т “Энэ журмыг үндэслэн тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно.”, 3-т “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.”, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 2-т “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж. Төрийн үйлчилгээний ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг тогтоох саналаа боловсруулан батлуулах, цалин хөлс холбоотой тогтоол, шийдвэрийг эрхлэх асуудлын хүрээнд батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэх, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: СХЗГ-ын Шинжилгээний зориулалттай Купеляцын зуух нийлүүлэх худалдан авах ажиллагааны нээлттэй тендерийн сонгон шалгаруулалт зохион байгуулан “Эф Ай Эф Өү” ХХК шалгарч ХА/01-51 дугаартай гэрээг 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр байгуулсан байна. Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд зуухыг нийлүүлээгүй хугацааг сунгасан, хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй байна. Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-т “хариуцлагатай байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулах, гэрээний гүйцэтгэлийг хангуулах.

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: СХЗГ-ын Хан-Уул дүүргийн 3 дугаар хороонд байрлалтай байрлалтай, 648 м.кв 777.6 сая төгрөгийн үнэтэй Сорьцын шинжилгээний барилгын газрын эзэмших эрхийн гэрчилгээгүй, бүртгэлд тусгаагүй байна. Барилгын газрын эзэмших эрхийг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэн үнэлж бүртгэлд тусгах талаар ТТЗ-д өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна. Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Газар эзэмших эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно", 27.3-т "Нэгж талбар бүр эрхийн гэрчилгээтэй байна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж. Харьяа байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй барилгын газрын эзэмших эрхийг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэн үнэлж бүртгэлд тусгах.

4. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: СХЗГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй Landcruiser-120 маркийн 15.0 сая төгрөгийн өртөгтэй 57-27 УБЧ улсын дугаартай тээврийн хэрэгсэл ослын улмаас 2017 оноос ашиглагдахгүй байна. СХЗГ-ын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар уг автомашиныг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлсэн боловч хэрэгжээгүй байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.4-т "ашиглах хугацаа дуусаагүй боловч осол, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх;", 67 дугаар зүйлийн 1. "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2."Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ." гэж заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж. Ашиглах боломжгүй болсон автомашиныг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг сайжруулж ажиллах.

5. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд олон жилийн насжилттай 73.1 сая төгрөгийн авлага бүртгэлтэй, барагдуулаагүй байна. Үүнээс СХЗГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн Акуатус ХХК-аас авах 10.5 сая төгрөг, Дэд бүтэц инженеринг ХХК-аас авах 17.8 сая төгрөгийн 5-6 жилийн насжилттай авлагыг барагдуулах албан шаардлага хэрэгжээгүй хууль, хяналтын байгууллагат шилжүүлсэн боловч эзэн холбогдогчийн хаяг тодорхойгүй шалтгаанаар

шийдвэрлэгдээгүй байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2.3."өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6."эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж. Харьяа байгууллагуудын авлагыг барагдуулах, шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

6. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ОБЕГ-ын харьяа Жаргалант сэргээн засах төв, 113 дугаар ангийн Улсын комисс хүлээн авсан эсэх нь тодорхойгүй, Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар аюулгүй байдлын хяналтын хэлтсийн 2021 оны дүгнэлтээр норм дүрмийн шаардлага хангахгүй болсон, ашиглах боломжгүйг тодорхойлсон дүгнэлттэй, 234.9 сая төгрөгийн балансын үнэтэй зоогийн газрын барилга ашиглагддаггүй бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.4-т "ашиглах хугацаа дуусаагүй боловч осол, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх", 67 дугаар зүйлийн 1. "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2."Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ." гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж. Ашиглах боломжгүй, чанарын шаардлага хангахгүй барилга байгууламжийг талаар холбогдох эрх бүхий байгууллагат хандаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, өмч хөрөнгийг ашиглалт хамгаалалтад хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулахад анхаарч ажиллах.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шадар сайдын харьяа байгууллагууд													
1	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	2	1,376.3	1	27.4	1	1,348.9	2	1,376.3			2	1,376.3
	ДҮН	2	1,376.3	1	27.4	1	1,348.9	2	1,376.3			2	1,376.3
Онцгой байдлын ерөнхий газар													
1	Онцгой байдлын ерөнхий газар	1	1,156.4			1	1,156.4	1	1,156.4			1	1,156.4
2	Үндэсний аврах бригад	1	82.0			1	82.0	1	82.0			1	82.0
3	Улсын шатахууны нөөцийн 112 дугаар анги	1	134.9	1	134.9			1	134.9			1	134.9
4	Хүнсний нөөцийн 179 дүгээр анги	1	150.0	1	150.0			1	150.0			1	150.0
5	Нийслэлийн онцгой байдлын газар	1	11.0	1	11.0			1	11.0			1	11.0
6	Баянгол дүүргийн ОБХ	3	1,023.1			3	1,023.1	3	1,023.1			3	1,023.1
7	Баянзүрх дүүргийн ОБХ	3	15.5			3	15.5	3	15.5			3	15.5
8	Сонгино хайрхан дүүргийн ОБХ	3	86.1			3	86.1	3	86.1			3	86.1
9	Хан-Уул дүүргийн ОБХ	1	6.7			1	6.7	1	6.7			1	6.7
10	Чингэлтэй дүүргийн ОБХ	1	1,006.7			1	1,006.7	1	1,006.7			1	1,006.7
11	Архангай аймгийн ОБГ	1	4.6	1	4.6			1	4.6			1	4.6
12	Баян-Өлгий аймгийн ОБГ	1	784.1			1	784.1	1	784.1			1	784.1
13	Баянхонгор аймгийн ОБГ	3	5.1	2	0.7	1	4.4	3	5.1			3	5.1
14	Булган аймгийн ОБГ	2	394.7			2	394.7	2	394.7			2	394.7
15	Говь-Алтай аймгийн ОБГ	1	37.7	1	37.7			1	37.7			1	37.7
16	Говьсүмбэр аймгийн ОБГ	1	4.2	1	4.2			1	4.2			1	4.2
17	Дархан-Уул аймгийн ОБГ	2	16,845.2			2	16,845.2	2	16,845.2			2	16,845.2
18	Дундговь аймгийн ОБГ	1	35.1	1	35.1			1	35.1			1	35.1
19	Өмнөговь аймгийн ОБГ	3	168.5			3	168.5	3	168.5			3	168.5
20	Сэлэнгэ аймгийн ОБГ	1	650.6	1	650.6			1	650.6			1	650.6

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21	Төв аймгийн ОБГ	6	97.4			6	97.4	6	97.4			6	97.4
22	Ховд аймгийн ОБГ	1	674.4			1	674.4	1	674.4			1	674.4
23	Хэнтий аймгийн ОБГ	1	2.1			1	2.1	1	2.1			1	2.1
	ДҮН	2	1,376.3	1	27.4	1	1,348.9	2	1,376.3			40	23,376.2
Стандарт, хэмжил зүйн газар													
1	Архангай аймгийн СХЗХ	2	7.2	1	2.9	1	4.3	2	7.2			2	7.2
2	Говь-Алтай аймгийн СХЗХ	1	1.8			1	1.8	1	1.8			1	1.8
3	Говьсүмбэр аймгийн СХЗХ	5	66.8	2	2.1	3	64.7	5	66.8			5	66.8
4	Дорноговь аймгийн СХЗХ	3	40.7			3	40.7	3	40.7			3	40.7
2	Дундговь аймгийн СХЗХ	6	20.8	2	2.4	4	18.5	6	20.8			6	20.8
3	Орхон аймгийн СХЗХ	1	0.8			1	0.8	1	0.8			1	0.8
4	Өмнөговь аймгийн СХЗХ	1	5.2	1	5.2			1	5.2			1	5.2
5	Төв аймгийн СХЗХ	4	45.0			4	45.0	4	45.0			4	45.0
3	Увс аймгийн СХЗХ	1	0.1			1	0.1	1	0.1			1	0.1
4	Хөвсгөл аймгийн СХЗХ	1	0.2			1	0.2	1	0.2			1	0.2
	ДҮН	25	188.7	6	12.6	19	176.1	25	188.7			25	188.7
	НИЙТ ДҮН	67	24,941.2	17	1,068.8	50	23,872.4	67	24,941.2			67	24,941.2

2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудал									
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан тушаалтан	Хууль хяналтын байгууллагад шилүүлэх асуудал
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Шадар сайд	7	1,398.0			1		6	1,398.0		
Шадар сайдын харьяа байгууллагууд											
1	Төрийн худалдан авах ажиллагааны газар	1	167.7			1	167.7				
2	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	4	8.2			3	7.2	1	1.0		
3	Үндэсний итгэмжлэлийн төв	3	35.0					3	35.0		
	ДҮН	8	210.8	0	0.0	4	174.9	4	36.0		
Онцгой байдлын ерөнхий газар											
1	ОБЕГ - ТТЗ	3	557.9			3	557.9	0	0.0		
2	ОБЕГ - аппарат	5	1,039.3			3	1,039.3	2	0.0		
3	Үндэсний аврах бригад	7	58.9	1	2.2	1	0.0	5	56.7		
4	Агаараас эрэн хайх 111 дүгээр анги	1	0.0					1	0.0		
5	Шатахууны нөөцийн 112 дугаар анги	0	0.0								
6	Жаргалант сэргээн заслын төв 113 дугаар анги	2	320.3			1	85.4	1	234.9		
7	Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төв 119 дугаар анги	2	73.5					2	73.5		
8	Хүнсний нөөцийн 179 дүгээр анги	0	0.0								
9	Улсын нөөцийн 185 дугаар анги	1	262.5			1	262.5				
10	Нийслэлийн онцгой байдлын газар	2	22.0			1	12.0	1	10.0		
11	Багануур дүүргийн ОБХ	3	10.0					3	10.0		
12	Багахангай дүүргийн ОБХ	1	0.0					1	0.0		
13	Баянгол дүүргийн ОБХ	1	3.9					1	3.9		
14	Налайх дүүргийн ОБХ	3	14.8					3	14.8		
15	Сонгинохайрхан дүүргийн ОБХ	2	7.5					2	7.5		
16	Сүхбаатар дүүргийн ОБХ	1	6.4					1	6.4		
17	Чингэлтэй дүүргийн ОБХ	1	0.5					1	0.5		
18	Архангай аймгийн ОБГ	4	6.0			2	6.0	2	0.0		
19	Баян-Өлгий аймгийн ОБГ	2	18.0					2	18.0		

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

20	Баянхонгор аймгийн ОБГ	4	36.1	1	0.4	1	4.8	2	30.9		
21	Булган аймгийн ОБГ	5	31.9	2	1.9	1	0.0	2	30.0		
22	Говь-Алтай аймгийн ОБГ	4	17.7			3	17.7	1	0.0		
23	Говьсүмбэр аймгийн ОБГ	2	11.8					2	11.8		
24	Дархан-Уул аймгийн ОБГ	3	2.5	2	2.5	1	0.0				
25	Дорнод аймгийн ОБГ	3	145.3			1	138.2	2	7.0		
26	Дундговь аймгийн ОБГ	1	2.2	1	2.2						
27	Завхан аймгийн ОБГ	3	48.6	1	0.6	1	48.0	1	0.0		
28	Орхон аймгийн ОБГ	4	47.8	2	2.2	2	45.7				
29	Өмнөговь аймгийн ОБГ	5	36.2	1	0.2	3	7.9	1	28.1		
30	Сэлэнгэ аймгийн ОБГ	9	26.2			6	26.2	3	0.0		
31	Төв аймгийн ОБГ	1	0.0					1	0.0		
	ДҮН	85	2,807.6	11	12.1	31	2,251.4	43	544.0		
Стандарт, хэмжил зүйн газар											
1	СХЗГ - ТТЗ	3	202.8			2	0.0	1	202.8		
2	СХЗГ - аппарат	3	73.4			3	73.4				
3	ХАБУЛЛ	9	50.6	2	2.2	3	27.8	4	20.5		
4	Баян-Өлгий аймгийн СХЗХ	1	71.2			1	71.2				
5	Баянхонгор аймгийн СХЗХ	3	45.1	1	0.5	1	4.4	1	40.1		
6	Говь-Алтай аймгийн СХЗХ	3	22.0			3	22.0				
7	Говьсүмбэр аймгийн СХЗХ	2	1.8	1	0.1	1	1.7				
8	Дорноговь аймгийн СХЗХ	2	0.3					2	0.3		
9	Дундговь аймгийн СХЗХ	3	2.0	2	2.0	1	0.0				
10	Орхон аймгийн СХЗХ	1	0.4	1	0.4						
11	Өвөрхангай аймгийн СХЗХ	1	9.7			1	9.7				
12	Өмнөговь аймгийн СХЗХ	3	0.2					3	0.2		
13	Сэлэнгэ аймгийн СХЗХ	1	0.0					1	0.0		
14	Төв аймгийн СХЗХ	4	20.4			2	18.9	2	1.5		
15	Ховд аймгийн СХЗХ	1	0.0					1	0.0		
16	Хөвсгөл аймгийн СХЗХ	2	46.7	1	0.1			1	46.6		
17	Хэнтий аймгийн СХЗХ	1	12.8			1	12.8				
	ДҮН	43	559.5	8	5.3	19	242.0	16	312.2		
	НИЙТ ДҮН	143	4,975.9	19	17.4	55	2,668.3	69	2,290.2		

3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа					
		Нийт зөрчил		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Онцгой байдлын ерөнхий газар							
1	Онцгой байдлын ерөнхий газар	1	0.0	1	0.0		
2	Ар талын 115 дугаар анги	1	0.0			1	0.0
3	Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв 119 дүгээр анги	1	0.0			1	0.0
4	Үндэсний аврах бригад	1	0.0			1	0.0
5	Нийслэлийн онцгой байдлын газар	1	0.0			1	0.0
6	Багануур дүүргийн ОБХ	2	14.0	1	14.0	1	0.0
7	Багахангай дүүргийн ОБХ	1	0.0			1	0.0
8	Баянгол дүүргийн ОБХ	2	880.0			2	880.0
9	Баянзүрх дүүргийн ОБХ	1	239.1			1	239.1
10	Налайх дүүргийн ОБХ	1	0.0			1	0.0
11	Хан-Уул дүүргийн ОБХ	1	0.0			1	0.0
12	Чингэлтэй дүүргийн ОБХ	1	0.0			1	0.0
13	Баянхонгор аймгийн ОБГ	1	0.0	1	0.0		
14	Булган аймгийн ОБГ	1	0.0			1	0.0
15	Говь-Алтай аймгийн ОБГ	2	0.0	2	0.0		
16	Орхон аймгийн ОБГ	1	0.0			1	0.0
17	Өмнөговь аймгийн ОБГ	2	2,716.6	2	2,716.6		
18	Сэлэнгэ аймгийн ОБГ	1	0.0	1	0.0		
19	Ховд аймгийн ОБГ	2	0.0			2	0.0
20	Хэнтий аймгийн ОБГ	2	129.0	1	129.0	1	0.0
	ДҮН	26	3,978.8	9	2,859.7	17	1,119.1
Стандарт хэмжил зүйн газар							
1	СХЗГ-ТТЗ	2	1,686.1	1	1,686.1	1	0.0
2	ХАБҮЛЛ	2	219.5	1	20.3	1	199.2
3	Баян-Өлгий аймгийн СХЗХ	1	32.3			1	32.3
4	Баянхонгор аймгийн СХЗХ	1	0.0	1	0.0		
5	Говь-Алтай аймгийн СХЗХ	1	20.1	1	20.1		
6	Дорноговь аймгийн СХЗХ	2	23.2			2	23.2

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

7	Дундговь аймгийн СХЗХ	1	0.0	1	0.0		
8	Өмнөговь аймгийн СХЗХ	1	17.0			1	17.0
9	Сүхбаатар аймгийн СХЗХ	1	0.0			1	0.0
	ДҮН	12	1,998.1	5	1,726.5	7	271.7
	Нийт дүн	38	5,977.0	14	4,586.1	24	1,390.8